



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

Стратеги батлах тухай

“Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.2, 8.1.11 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хөгжлийн бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги”-ийг нэгдүгээр, тус стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан стратегийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусган хэрэгжүүлэхийг холбогдох газар хэлтэс, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал, эрхлэгч, ерөнхий эмч нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөл болон зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлэхийг Стратегийн бодлого төлөвлөлтийн газар (Р.Оюунханд), аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Ганчимэг)-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080597

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 01 сарын 07 ний өдрийн
181 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ 2015-2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ СТРАТЕГИ

Алсын хараа

Монгол улсад үзүүлж буй эмнэлгийн тусламж, үйлчилгээ нь хүн амын эрүүл мэндийн эрсдэл, өвчлөл, нас баралтыг бууруулж, дундаж наслалтыг уртасган, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн түвшинг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Эрхэм зорилго

Монгол улсын иргэн бүрт шаардлагатай үед нь анагаах ухааны нотолгоонд суурилсан үр дүнтэй, аюулгүй эмнэлгийн тусламж, үйлчилгээг чанартай, тасралтгүй, тэгш хүртээмжтэй, чирэгдэлгүй үзүүлэхэд оршино.

Зорилго:

Эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын эрэлт, хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүй байдлыг хангасан, ил тод, хариуцлагатай, үр дүнтэй, үйлчлүүлэгч төвтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээний тогтолцоо болгон хөгжүүлнэ.

Эрхэмлэх үнэт зүйлс

- Үйлчлүүлэгч төвтэй, тэгш, хүртээмжтэй үйлчилгээ
- Ашгийн төлөө бус, үр дүнтэй, чанартай тусламж, үйлчилгээ
- Ил тод, хариуцлагатай, мэргэжлийн нэгдмэл удирдлага
- Оновчтой хөрөнгө оруулалт, мэдрэмжтэй хуваарилалт
- Өндөр бүтээмжтэй, нотлогдсон технологи
- Эрх тэгш, нээлттэй, тогтвортой түншлэл

Хэрэгжүүлэх зарчим

- Иргэдийн эрүүл мэндийн байдал, оршин суугаа газар, нас, хүйс, боловсрол, бэлгийн чиг хандлага, үндэс угсаа, хэл соёлын ялгаанаас үл хамааран тэгш хүртээмжтэй хүргэх;
- Чанар, аюулгүй байдлыг хангасан, нотолгоонд суурилсан технологийг ашиглах;
- Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан байх;
- Өвчин эмгэгийг эрт илрүүлж, чанартай, шуурхай, тасралтгүй, үр дүнтэй эмчлэх;
- Санхүүжилтийн тогтвортой, үр ашигтай, ил тод, хариуцлагатай байдлыг хангах;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлд хамтрагч талуудын оролцоог адил тэгш хангах;

	Бодлогын зорилт 2014-2023	Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги	Хүлээгдэж буй үр дүн
1	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг хүн амын эрэлт хэрэгцээ, суурьшил, нягтрал, хүн амын өвчлөлийн чиг хандлагад нийцүүлэн оновчтой болгож, тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхээс бусад үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, нотолгоонд суурилсан мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоог бэхжүүлнэ.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрөл саарч, тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.
2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эрсдлийг бууруулна.	Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний үр дүнтэй арга, технологийг нэвтрүүлж, чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн эмнэлзүйн эрсдлийн удирдлага, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ.	Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирсан байна.
3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний соёл, харилцаа, хандлагыг төлөвшүүлнэ.	Үйлчилгээний тав тухтай орчныг бүрдүүлж, үйлчилгээний зохицуулалтын мэдээллийг үйлчлүүлэгчдэд ойлгомжтой, шуурхай хүргэх, сэтгэлзүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоог бүрдүүлнэ.	Эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний соёл нэвтэрч эхэлсэн байна.
4	Эрүүл мэндийн байгууллагуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн удирдлагын хариуцлага, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.	Эмнэлгийн засаглалын бие даасан байдлыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн удирдлагын хариуцлага, ил тод байдлыг дэмжих олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний засаглалын бие даасан байдал, хариуцлага, ил тод байдал сайжирсан байна.
5	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний найдвартай, тогтвортой үйл ажиллагаа, гүйцэтгэл, чанар, үр дүнг дэмжсэн санхүүжилтийн тогтолцоог бий болгоно.	Эрүүл мэндийн даатгалын багцыг өргөжүүлж, гүйцэтгэл, чанар, үр дүнг дэмжсэн төсөвлөлт, хөрөнгө оруулалтын нэгдсэн зохицуулалт, цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.	Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл, чанар, хүртээмжийг дэмжсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоо бүрдсэн байна.
6	Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл, бодит эрэлт хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлнэ.	Тусламж, үйлчилгээний ачаалал хуваалцах, өндөр технологи нэвтрүүлэх, дэд бүтцийг барьж байгуулах, дэмжих үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	Тусламж, үйлчилгээний бодит эрэлт, хэрэгцээг хангах, ачаалал хуваалцахад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна.

Стратегийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Стратегийн хэрэгжилтийг жил бүр тайлагнаж, хэрэгжилтийн дунд хугацааны хяналт-шинжилгээг 2017 онд, хэрэгжилтийн төгсгөлийн үнэлгээг 2019 онд тус тус ЭМСЯ-ны Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар хийнэ.



Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 1		Хүрэх үр дүн		
Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхээс бусад үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, нотолгоонд суурилсан мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоог бэхжүүлнэ.		Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрөл саарч, тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.		
№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	Гэрийн эмчилгээ, асаргаа сувилгааг үзүүлж буй өрх, сумын эрүүл мэндийн төвийн эзлэх хувь	-	30%	80%
2	Өрх, сумын эрүүл мэндийн төвд шинээр нэвтрүүлсэн тусламж үйлчилгээний нэр төрлийн тоо	-	4	5
3	Хүүхдийг үзэхдээ ХӨЦМ-ийн удирдамжийн дагуу үнэлдэг өрх, сумын эмч нарын эзлэх хувь	52% (2013 он)	70%	80%
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэлтэд хамрагдсан зорилтот насны эмэгтэйчүүдийн хувь	41,6% (2012 он)	60,0%	70,0%
5	Хамрагдвал зохих хүмүүсийн артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хувь	38,5% (2012 он)	60,0%	70,0%
6	Нэгдсэн эмнэлэгт шинээр нэвтрүүлсэн тусламж, үйлчилгээний нэр төрлийн тоо	-	5	13
7	Асаргаа сувилгаа, хөнгөвчлөх эмчилгээний нэгж бүхий нэгдсэн эмнэлгийн тоо	-	21	30
8	Хавдрын хими эмчилгээг шинээр нэвтрүүлсэн нэгдсэн эмнэлгийн тоо	-	5	21
9	Өдрийн эмчилгээнд шинээр нэмэгдсэн эмчилгээ, үйлчилгээний нэр төрлийн тоо	-	5	10
10	Телемедицины сүлжээнд хамрагдсан сумдын тоо	-	50	100

Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 2		Хүрэх үр дүн		
Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний үр дүнтэй арга, технологийг нэвтрүүлж, чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн эмнэлзүйн эрсдлийн удирдлага, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ.		Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирсан байна.		
	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	Шинээр болон шинэчлэн боловсруулсан эмнэлзүйн удирдамж, стандарт, заавар, хөтчийн тоо	-	30	50

2	Эмнэлзүйн эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж, үйл ажиллагаа нь тогтмолжсон эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	-	80%	95%
3	Үндсэн оношийн зөрүүний хувь	5,6 (2013 он)	5,0	4,5
4	Тусламж, үйлчилгээний төрлөөр магадлан итгэмжлэгдсэн байгууллагын тоо	-	10	20
5	Жирэмсэн, төрөлт, төрсний дараахь үеийн хүндрэл, 1000 амьд төрөлтөд	741 (2012 он)	700	650
6	Сүрьеэ өвчнөөр эмчлүүлж байсан хүмүүсээс ОЭТС гэж оношлогдсон хүмүүсийн хувь	28% (2008 он)	25%	20%
7	Хорт хавдартай хүмүүсийн хожуу үедээ (III, IV) оношлогдсон хувь	75.9% (2013 он)	70.0%	65.0%
6	Эмнэлгийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан нөхцөлд сэргийлж болох нас баралтын түвшин, 100,000 хүн амд	251,5 (2011 он)	240,0	220,0

Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 3		Хүрэх үр дүн		
Үйлчилгээний тав тухтай орчныг бүрдүүлж, үйлчилгээний зохицуулалтын мэдээллийг үйлчлүүлэгчдэд ойлгомжтой, шуурхай хүргэх, сэтгэл зүйн мэргэжлийн зөвлөгөө өгөх тогтолцоог бүрдүүлнэ.		Эрүүл мэндийн байгууллагуудад үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний соёл нэвтэрч эхэлсэн байна.		
	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	Хөндлөнгийн судалгаагаар эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дундаас дээш гэсэн сэтгэл ханамжийн үнэлгээ өгсөн үйлчлүүлэгчийн эзлэх хувь	29,5% (2013 он)	40%	60%
2	Сэтгэл зүйн үйлчилгээ бүхий эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	-	30%	60%
3	Тэргэнцэртэй үйлчлүүлэгчид зориулсан налуу замтай эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	56,0% (2013 он)	60%	80%
4	Тусламж, үйлчилгээний зохицуулалтын талаар мэдээллийн хөтөч, цахим хуудас ажиллуулдаг эрүүл мэндийн байгууллагуудын эзлэх хувь	-	50%	90%
5	Эмнэлгээр үйлчлүүлэхэд хаана хэнд хандахаа мэдэхгүй, хөтөч үйлчилгээ байхгүй гэж үнэлсэн үйлчлүүлэгчийн эзлэх хувь	51,7% (2013 он)	30%	10%
6	Налуу зам бүхий эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	-	50%	80%
7	Хүлээлгийн танхимын тав тух сайн, суух сандал хүрэлцээтэй гэж үнэлсэн үйлчлүүлэгчийн эзлэх хувь	33,0% (2013 он)	40%	60%
8	Эмнэлэгт очих унаа, зам хялбар, автомашины зогсоолтой гэж үнэлсэн үйлчлүүлэгчийн эзлэх хувь	24,6% (2013 он)	40%	60%

Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 4		Хүрэх үр дүн		
Эмнэлгийн засаглалын бие даасан байдлыг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлж, санхүүгийн удирдлагын хариуцлага, ил тод байдлыг дэмжих олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.		Эмнэлгийн тусламж, үйлчилгээний засаглалын бие даасан байдал, хариуцлага, ил тод байдал сайжирсан байна.		
	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	Эмнэлгийн засаглалын бие даасан байдлыг сайжруулах зорилгоор гаргасан хууль, эрх зүйн шийдвэр	-	1	1
2	Удирдлага, санхүүгийн талаар гаргасан шийдвэрээ цахим хуудсаар хамт олон, иргэддээ ил тод мэдээлдэг байгууллагын эзлэх хувь	40% (2013 он)	60	80
3	Гүйцэтгэлийн гэрээний үнэлгээг санхүүжилттэй нь уялдуулсан тушаал шийдвэр, эрх зүйн баримт бичиг	-	1	1
4	Гүйцэтгэлийн гэрээний үнэлгээг олон нийтэд танилцуулдаг байгууллагын эзлэх хувь	-	60	80
5	Үйлчлүүлэгч эмнэлгийн тусламж, үйлчилгээнд төлсөн төлбөрт албан бус төлбөрийн эзлэх хувь	62,7% (2011 он)	50	35

Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 5		Хүрэх үр дүн		
Эрүүл мэндийн даатгалын багцыг өргөжүүлж, гүйцэтгэл, чанар, үр дүнг дэмжсэн төсөвлөлт, хөрөнгө оруулалтын нэгдсэн зохицуулалт, цалин урамшууллын тогтолцоог бүрдүүлнэ.		Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэл, чанар, хүртээмжийг дэмжсэн санхүүжилт, хөрөнгө оруулалтын тогтолцоо бүрдсэн байна.		
	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	ЭМД-ын гэрээ байгуулсан эмнэлгүүдийн тусламж, үйлчилгээний санхүүжилтэд эрүүл мэндийн даатгалын эзлэх хувь	50% (2013 он)	70%	80%
2	Хувь хүн эрүүл мэнддээ шууд төлж буй зардлын эзлэх хувь	41% (2011 он)	35%	30%
3	Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээтэй уялдуулсан төсөвлөлтийн шинэ аргачлал	-	1	1
4	Ажлын ачаалал, хөдөлмөрийн бодит үнэлэмжтэй уялдсан цалин урамшууллын эрх зүйн шийдвэр	-	1	1
5	Эмнэлгийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн ашиглалтад хийсэн үнэлгээний тоо	-	1	1
6	Даатгалд хамруулсан эмнэлгийн тоног төхөөрөмжийн эзлэх хувь	-	20%	30%
7	Эмнэлгийн дэд бүтэц, тоног төхөөрөмжийн ашиглалтын хяналт, тохиргоо, баталгаажуулалт хийх эрх зүйн шийдвэр	-	1	1

Бодлогыг 2015-2019 онд хэрэгжүүлэх стратеги 6 Тусламж, үйлчилгээний ачаалал хуваалцах, өндөр технологи нэвтрүүлэх, дэд бүтцийг барьж байгуулах, дэмжих үйлчилгээнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.		Хүрэх үр дүн Тусламж, үйлчилгээний бодит эрэлт, хэрэгцээг хангах, ачаалал хуваалцахад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдсэн байна.		
	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2017 оны түвшин	2019 оны түвшин
1	Эрүүл мэндийн байгууллагууд өндөр өртөгтэй тоног төхөөрөмж, үйлчилгээг түрээслэх, гэрээгээр үйлчлэх хэлбэрээр хамтран ашиглах журам	-	1	1
3	Төрийн чиг үүрэгт хамаарах эмнэлгийн тусламж, үйлчилгээг гэрээгээр үзүүлэх жагсаалт, журам	-	1	1
4	Эрэлт хэрэгцээтэй уялдуулан шинэчлэн боловсруулсан тусгай зөвшөөрлийн журам	-	1	1
5	Хувийн хэвшлийн эмнэлгийн үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийн сан	-	1	1
6	Орон нутгийн эрүүл мэндийн сүлжээний хүрээнд төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд ачаалал хуваалцан хамтран ажиллах журам	-	1	1

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 05 сарын 04 өдрийн
18-р дугаар тушаалын
2 дугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ 2015-2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
СТРАТЕГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
Стратеги 1. Хүн амын эрэлт хэрэгцээтэй уялдуулан тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулж, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэхээс бусад үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн, нотолгоонд суурилсан мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоог бэхжүүлнэ.								Хүлээгдэж буй үр дүн 1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрөл саарч, тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.				
Бодлогын чиглэл: 1.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хаалга баригч болох өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг сум, тосгон тус бүрт нэг, хот суурин газрын 6000-12000 хүн тутамд нэг байхаар зохион байгуулж, тусламж, үйлчилгээг өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа, сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний чиглэлээр өргөжүүлнэ.												
1.1.1	Хүн амын эрэлт хэрэгцээг судалж, аймаг, хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдсан ӨЭМТ-ийн байршлын зураглалыг боловсруулна.	+	+				Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Байршлын зураглал	ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 16.8	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 24 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 24 хүн/сар ажиллахаар тооцов.
1.1.2	Судалгаанд үндэслэн шинээр байгуулах Өрхийн эрүүл мэндийн төвийн тоо хэмжээ, хамрах хүрээг шинэчлэн тогтооно.		+	+			ӨЭМТ-ийг байгуулах, татан буулгах эрх зүйн орчин тодорхой болно.	Засгийн газрын тогтоол	ЭМСЯ-ны СБТГ, ЭМБХЗГ ЭТХ, Аймаг нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯ,	Улсын төсөв 16.8	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 24 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 24 хүн/сар ажиллахаар тооцов.
1.1.3	Өрх, сумын ЭМТ-ийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхэд шаардагдах санхүүжилт, хүний нөөцийн хэрэгцээг тогтоох судалгааг хийнэ.	+	+				Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Тайлан, зөвлөмж	ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, Олон улсын байгууллага (ОУБ)	Төсөл хөтөлбөр 12.0	Зөвлөх үйлчилгээг дунджаар 3 сая төг-ийн цалинтайгаар 4 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.1.4	Өрх, сумын ЭМТ-ийн үзүүлэх гэрийн эмчилгээ, асаргаа, сувилгааны заавар, журмыг боловсруулж, батлуулна.		+				Нотолгоонд суурилсан арга зүйн удирдамжаар хангагдана.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Улсын төсөв 5.6	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 8 хүн/сар ажиллахаар тооцов.
1.1.5	ӨЭМТ бүр цахим бүртгэл, үйлчлэх хүрээний хүн амдаа эрүүл мэндийн үзлэг, хяналтын хуваарь, зөвлөгөө, санамж өгөх, иргэдтэй харилцах олон нийтийн цахим хуудастай болно.	+	+				Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын цахим тогтолцоо бүрдэнэ.	Цахим хуудас, программ хангамж, хандалтын тоо	Аймаг, нийслэлийн ЭМГ, ӨЭМТ	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо, ОУБ	Төсөл хөтөлбөр 120.0	Гэрээгээр гүйцэтгэх веб хуудас хийх зардал 0.3 сая төгрөг, интернет серверт байршуулах 1 жилийн төлбөр 0.2 сая, 240 ӨЭМТ-д хийхээр зардлыг тооцов.
1.1.6	ӨЭМТ-ийн ажлын цагийг нь ажлын цагийг нь томуугийн дэгдэлт, иргэдийн ажлын цаг, сурагчдын амралттай уялдуулан ээлжийн болон уртасгасан цагаар ажиллах асуудлыг гэрээнд тусган шийдвэрлэнэ.	+	+				Үйлчилгээний зохицуулалт иргэдийн хэрэгцээнд нийцүүлэх эрх зүйн орчин сайжирна.	Цагийн зохицуулалт хийгдсэн гэрээний тоо, тайлан	ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын ЭТХ, Аймаг, нийслэлийн ЭМГ, ӨЭМТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Улсын төсөв 16.8	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 24 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 24 хүн/сар ажиллахаар тооцов.
1.1.7	Сум, тосгон, ӨЭМТ-ийн эмч, мэргэжилтнүүдийг өрхийн анагаах ухаан, ХӨЦМ, хөнгөвчлөх, сэргээн засах, гэрийн эмчилгээ, асаргаа сувилгааны чиглэлээр тасралтгүй сургалтанд хамруулж, мэргэшүүлнэ.		+	+	+	+	Сум, тосгон, ӨЭМТ-ийн эмч, сувиллагч нарын мэдлэг ур чадвар сайжирна.	Сургалтанд хамрагдсан хүний тоо	ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ, Сум, тосгоны ЭМТ, ӨЭМТ	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 36.0	Анхан шатны эмч мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтын зардлыг тооцов.
1.1.8	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд стандартын дагуу шаардагдах тоног төхөөрөмжөөр хангана.	+	+	+	+	+	Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны СЭЗХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 2,522,0	Жил тутамд 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг төсөвт тусгахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
Бодлогын чиглэл: 1.2 Алслагдсан болон газар зүйн саад бэрхшээлтэй нутагт оршин сууж буй иргэд, отрын малчид, уул уурхайн ажилчид, шинээр шилжин суурьшсан иргэд гэх мэт хөдөлгөөнт хүн амд иргэний бүртгэлийг үл харгалзан, оршин буй газартаа эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах эрх зүйн орчныг бүрдүүлж, тусламж, үйлчилгээний тэгш байдлыг хангана.												
1.2.1	Хөдөлгөөнт хүн амд тусламж, үйлчилгээг үзүүлэхэд гарах зардлыг иргэний харъяаллын бүртгэлийг үл харгалзан санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	+	+				Тусламж, үйлчилгээний тэгш байдал, хүртээмж нэмэгдэнэ.	Сангийн сайд, ЭМС-ын сайдын хамтарсан тушаал	ЭМСЯ-ны СЭЗХ, ЭМБХЗГ ЭТХ,	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯ, ЭМД-ын газар	Улсын төсөв 8.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 3 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 12 хүн/сар ажиллахаар тооцов.
1.2.2	Алслагдсан нутгийн иргэд, отрын малчид, бичил уурхай эрхлэгчдэд үзүүлэх нүүдлийн /явуулын/ амбулаторийн үйлчилгээний багцыг тодорхойлно.		+				Тусламж, үйлчилгээний тэгш байдал нэмэгдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Аймаг нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 5.6	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 8 хүн/сар ажиллахаар тооцов.
1.2.3	Эмнэлгээс гарсны дараах барих дэглэм, асаргаа сувилгаа, үйлчилгээний талаар гар утасны "эрүүл мэндийн ухаалаг зөвлөгөө" өгөх журам боловсруулж, хэрэгжүүлнэ.			+	+		Эмчилгээ үйлчилгээний тасралтгүй байдал сайжирна.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, ЭМХТ, Аймаг нийслэлийн ЭМГ	СЯ, МТШХХГ	Улсын төсөв 12.0	Тухайн байгууллагын төлөвлөгөө, төсвийн хүрээнд тусган хэрэгжүүлэхээр тооцов.
Бодлогын чиглэл: 1.3 Аймгийн төвөөс 100 км-ээс дээш алслагдсан сумдыг ойролцоо газар нутгаар нь 10000-20000 хүн амд нэг байхаар тойрог болгон аль хүн ам төвлөрсөн суманд нь сум дундын эмнэлгийг зохион байгуулж, эмнэлгийн анхан шатны болон үндсэн мэргэжлийн зарим тусламж, үйлчилгээг хослуулан үзүүлнэ.												
1.3.1	Телемедицины үндэсний сүлжээгээр алслагдсан сумдад үзүүлэх зөвлөх үйлчилгээний багцыг тодорхойлно.		+	+			Сумдад телемедици- ны үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, ЭМХТ, Аймаг нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 16.1	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 23 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 23 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.3.2	Сумдыг телемедицины үндэсний сүлжээний дэд бүтцэд холбох төлөвлөгөөг аймаг бүрээр боловсруулж, хэрэгжүүлнэ.		+				Телемедици- ны дэд бүтэц үндэсний хэмжээнд холбогдоно.	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтэд хийсэн үнэлгээ	ЭМХТ, Аймаг нийслэлийн ЭМГ, СЭМТ, хөдөөгийн НЭ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯ	Улсын төсөв 15.4	Тухайн 22 байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 22хүн/сар ажиллахаар тооцов.
1.3.3.	Сум дундын эмнэлэгт үзүүлж байгаа үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээний өнөөгийн хэрэгцээ, байршил, үйлчлэх хүрээг судлан, эрх зүйн орчинг сайжруулна.		+				Яаралтай мэс засал, ЭБЯТ, ННШТ-ыг 2 цагийн дотор үзүүлэх нөхцөл сайжирна.	Засгийн газрын тогтоол	ЭМСЯ-ны СБТГ, СЭЗХ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯ	Улсын төсөв 7.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 ажилтан дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 10 хүн/сар ажиллахаар тооцов.
1.3.4.	Сум дундын эмнэлэгт эх нярайн болон мэс заслын яаралтай тусламжийг үзүүлэх чиглэлээр хүний нөөцийг мэргэшүүлж, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлнэ.		+	+	+		Алслагдсан сумдад яаралтай мэс заслын тусламжийн хүртээмж сайжирна.	Сургалтанд хамрагдсан хүний тоо, тоног төхөөрөмжийн хангалт	ЭМХТ, ЭМСЯ- ны СБТГ-ын СЭЗХ, ЭМБХЗГ, ЭТХ, Аймагийн ЭМГ, СДЭ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯ	Улсын төсөв 160,0	30 мэс заслын эмчийг УБ хотод 6 сарын сургалтанд хамруулах зардал, 30 сум дундын эмнэлгийг тоног төхөөрөмжөөр хангах зардлыг тооцов.
Бодлогын чиглэл:												
1.4 Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээг нэгдсэн эмнэлэгт тулгуурлан олон улсын жишигт хүргэн хөгжүүлэх бөгөөд өмчийн олон хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагатай ачаалал хуваалцах, тусламж, үйлчилгээний дутагдалтай хэсгийг нөхөх, орлуулах байдлаар хамтран ажиллана.												
1.4.1	Тухайн нэгдсэн эмнэлгийн ачаалалтай уялдуулан амбулатори үйлчилгээ, өдрийн эмчилгээг ээлжийн системээр уртасгасан цагаар үйлчлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.		+	+			Тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 10.5	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 30 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 15 хүн/сар ажиллахаар тооцов.
1.4.2	Нэгдсэн эмнэлгийн эмч нарыг амбулатори, хэвтүүлэн эмчлэх тасгуудад сэлгэн ажиллуулах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.			+	+	+	Үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээний зохицуулалт сайжирна.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 10.5	Нийт 30 байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 15 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.4.3	Нэгдсэн эмнэлгийн үзүүлэх тусламж, үйлчилгээний багцыг боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+				Өвчтөн шилжүүлэх эрх зүйн орчин тодорхой болно.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл, НЭ	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 10.5	Нийт 30 байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 15 хүн/сар ажиллахаар тооцов.
1.4.4	Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн бүтцэд урт хугацааны асаргаа сувилгааны нэгж байгуулна.			+	+	+	Архаг хүнд өвчтний үйлчилгээний тасралтгүй байдал сайжирна.	Эрүүл мэндийн сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, СБТГ СЭЗХ, Аймаг нийлэлийн ЭМГ, НЭ	СЯ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 4.2	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 6 хүн/сар ажиллахаар тооцов.
Бодлогын чиглэл: 1.5 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг үйл ажиллагааны нэгдмэл зохион байгуулалтад шилжүүлж тусламж, үйлчилгээний уялдаа холбоо, залгамж чанар, хүртээмж, тасралтгүй байдлыг сайжруулна. Зарим өндөр өртөгтэй тоног төхөөрөмж, дэмжих үйлчилгээг гэрээгээр хамтран ашиглах замаар нөөц ашиглалтыг сайжруулна.												
1.5.1	150 мянган хүнд нэг байхаар орон нутгийн эрүүл мэндийн сүлжээг байгуулах, түүний харилцааг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.		+	+	+	+	Сүлжээг байгуулах эрх зүйн орчин бүрдэнэ.	Засгийн газрын тогтоол	ЭМСЯ-ны СБТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗДТГ	СЯ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 14.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 45 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 20 хүн/сар ажиллахаар тооцов.
1.5.2	Сүлжээний хүрээнд хүүхдийн шүд, нярайн амбулатори, хүүхдийн ерөнхий мэс засал, хавдрын хими эмчилгээ, гемодиализ, гэмтэл, мэс заслын чиглэлээр ачаалал хуваалцах хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.		+	+	+	+	Тусламж, үйлчилгээний төвлөрөл саарч, хүртээмж нэмэгдэнэ.	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол	ЭМСЯ-ны СБТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ	СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 14.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 45 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 20 хүн/сар ажиллахаар тооцов.
1.5.3	Эрүүл мэндийн сүлжээ байгуулах төлөвлөгөөг нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран боловсруулж, батлуулна.		+	+			Нотолгоонд суурилсан шийдвэр гарна.	Хамтарсан захирамж, тушаал	Аймаг, нийслэлийн ЭМГ, ЗД, ЭМСЯ-ны СБТГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ,	Төсөл хөтөлбөр 8.0	Хэлэлцүүлэх зардал тооцов

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.5.4	Сүлжээний хүрээнд тусламж, үйлчилгээний зохицуулалт, уялдаа холбоо, тасралтгүй байдлыг дэмжих орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.		+	+			Тусламж, үйлчилгээний зохицуулалтад иргэний оролцоог хангах эрх зүйн орчин бүрдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны СБТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ТББ	Улсын төсөв 16.1	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 23 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 23 хүн/сар ажиллахаар тооцов.
1.5.5	Сүлжээний хүрээнд үйлчилгээний зохицуулалт, эмнэлгийн хүлээгдэл, ачаалал, цаг товлох, мэдээллийг цаг алдахгүй өгөх, өвчтөнг шилжүүлэхийн өмнөх, дараах мэдээлэл, зөвлөгөө өгөх цахим үйлчилгээ бий болгоно.				+	+	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалтын цахим тогтолцоо бүрдэнэ.	Сайдын тушаал	ЭМХТ, ЭМСЯ-ны ЭТХ, ХШУДАГ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 30.0	Програм хангамж хөгжүүлэх, суурилуулах, сургалт, үйл ажиллагааны зардал тооцов
1.5.6	Орон нутгийн эрүүл мэндийн сүлжээг байгуулахад шаардагдах эдийн засгийн тооцоо судалгаа хийж, төсвийн төлөвлөгөөнд тусгах арга хэмжээг зохион байгуулна.		+	+	+	+	Бодлогын зорилтыг бодитойгоор хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.	Тооцоо судалгаа, Батлагдсан төсөв	ЭМСЯ-ны СЭЗХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	СЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 16.1	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 23 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 23 хүн/сар ажиллахаар тооцов.
Бодлогын чиглэл:												
1.6 Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг, аймгийн төв бүрт, хотын төвийн дүүрэгт 150 мянган хүн ам тутамд, аймгийн төвөөс алслагдсан бөгөөд хоорондоо 50 км-ээс ойр оршиж буй сумдын 20000-аас доошгүй хүн амд нэг байхаар тус тус тооцон нэгдсэн эмнэлгийг зохион байгуулж, үйлчлүүлэгч олон мэргэжлийн тусламжийг нэг цэгээс авах боломжийг бүрдүүлнэ.												
1.6.1	Улаанбаатар хотын нэгдсэн эмнэлгийг байршлын зураглалыг боловсруулж, Нийслэлийн дунд болон урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгуулна.		+				Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Байршлын зураглал	ЭМХТ, Нийслэлийн ЭМГ	Нийслэлийн ЗДТГ, СЯ,	Улсын төсөв 6.3	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 3 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 9 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.6.2	Загвар нэгдсэн эмнэлгийг Сонгинохайрхан дүүрэгт байгуулна.		+	+	+		Загвар эмнэлэг ашиглалтад орсон байна.	Улсын комисс хүлээн авсан дүгнэлт	ЭМСХХ-4 төсөл, ЭМСЯ-ны ЭМБХЗГ, НЭМГ	Нийслэлийн ЗДТГ, СЯ,	Улсын төсвөөс 4,560.0 Төслөөс 61,940.0	ЭМСХХ-4 төслөөс барилга барихад 25 сая, тоног төхөөрөмж авахад 7,6 сая ам.доллараар тус тус санхүүжүүлнэ.
1.6.3	Сонгинохайрхан дүүрэгт байгуулах Загвар нэгдсэн эмнэлгийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+				Загвар эмнэлгийн үйл ажиллага тодорхой болно.	Батлагдсан төлөвлөгөө, тайлан, үнэлгээ	ЭМСХХ-4 төсөл, ЭМСЯ-ны ЭМБХЗГ, НЭМГ,	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 156.0	ДЭМБ-ын зөвлөх 4 сар ажиллах зардлыг тооцов.
1.6.4	Загвар нэгдсэн эмнэлгийн жишгээр нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартад оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж боловсруулна.		+	+			Шийдвэр гаргахад олон талын оролцоог хангах боломж бүрдэнэ.	Тайлан, зөвлөмж	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, ЭМСХХ-4 төсөл	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 5.0	ЭМСХХ-4 төслөөс 2500 ам.доллараар санхүүжүүлэхээр тооцов.
1.6.5	Аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ тус бүрийн хүчин чадлыг судалж, стандартын түвшинд хүргэн хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, эдийн засгийн тооцоо судалгааг хийж, зардлыг жил бүрийн төсөвт тусгах арга хэмжээг зохион байгуулна.			+	+	+	Стандартын шаардлага хангасан нэгдсэн эмнэлгийн тогтолцоо бий болно.	Тооцоо судалгаа, батлагдсан төсөв	ЭМХТ ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, БМТГ СЭЗХ, Нийслэлийн ЭМГ	Нийслэлийн ЗДТГ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 5.0	ЭМСХХ-4 төслөөс 2500 ам. доллараар санхүүжүүлэхээр тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.6.6	Хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн хүчин чадал, хүн амын хэрэгцээнд тулгуурлан тусламж, үйлчилгээний багц, үйлчлэх хүрээний зураглалыг шинэчлэн боловсруулж, стандартын түвшинд хүргэн хөгжүүлэх төлөвлөгөөг эмнэлэг бүрээр боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+				Хөдөөгийн нэгдсэн эмнэлгүүдийн бүтэц үйл ажиллагаа стандартын түвшинд хүрсэн байна.	Батлагдсан төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, үнэлгээ	ЭМСЯ-ны СБТГ, ЭМБХЗГ ЭТХ, ЭМХТ, Аймгийн ЭМГ, НЭ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв 22.0	Тухайн байгууллагын төлөвлөгөө, төсвийн хүрээнд тусган хэрэгжүүлэхээр тооцов.
Бодлогын чиглэл: 1.7 Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвд үзүүлж буй зарим тусламжийг нэгдсэн эмнэлэгт үе шаттай шилжүүлж, хүүхэд, төрөх эмэгтэйчүүд, хавдар, арьс, сэтгэц, халдварт, гэмтэл, мэс засал, уламжлалт, эмнэлэг хүртэлх яаралтай тусламж, эмнэлгийн сэргээн засах, өдрийн, хөнгөвчлөх үйлчилгээний чиглэлээр чадавхийг нэмэгдүүлэн үндсэн болон зарим төрөлжсөн мэргэжлийн үйлчилгээг нэгдсэн эмнэлэгт хослуулан үзүүлэх боломжийг дэмжинэ.												
1.7.1	Хүүхдийн ерөнхий мэс засал, нярайн эмгэг судлал, сэтгэц, гэмтэл, мэс засал, хөнгөвчлөх, хавдар, эмнэлгийн сэргээн засах, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний ачааллыг нэгдсэн эмнэлэгт шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.		+	+	+		Төвлөрлийг сааруулж, зарим ачааллыг орон нутагт шилжүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭТХ, СЭЗХ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Мэргэжлийн салбар зөвлөл	СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 6.3	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд 18 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 9 хүн/сар ажиллахаар тооцов.
1.7.2	Ачааллыг үе шаттай шилжүүлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах удирдамжийг мэргэжлийн салбар бүрээр боловсруулж, батлуулна.		+	+			Ачаалал шилжүүлэх үйл явц мэргэжлийн удирдлагаар хангагдана.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ, ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 12.0	Зөвлөх үйлчилгээг дунджаар 3 сая төг-ийн цалинтайгаар 4 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.7.3	Ачаалал шилжиж, нэгдсэн эмнэлэгт шинээр нэмэгдсэн оношилгоо, эмчилгээний зардлын эдийн засгийн тооцоо судалгааг хийж, төсөвт тусгах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.			+	+	+	Ачаалал шилжүүлэх төлөвлөгөө хэрэгжих бодит нөхцөл бүрдэнэ.	Засгийн газрын тогтоол	ЭМСЯ-ны СЭЗХ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 14.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 40 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 20 хүн/сар ажиллахаар тооцов.
1.7.4	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн нэгж ба "Яаралтай тусламжийн үндэсний сүлжээ"-ний хүрээнд уялдаатай ажиллах асуудлыг зохицуулах чиглэлээр журам боловсруулж, хэрэгжүүлнэ.		+	+			Яаралтай тусламжийг зохицуулах эрх зүйн орчин тодорхой болно.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Нийслэлийн ЭМГ	СЯ, Нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 4.2	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 6 хүн/сар ажиллахаар тооцов.
Бодлогын чиглэл:												
1.8 Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төвүүдийг тухайн мэргэжлээрээ тусламж, үйлчилгээний хөгжлийг тодорхойлж, улсын хэмжээний лавлагаа, дүгнэлт гаргах, эмнэлзүйн удирдамж, стандарт, хөтөч боловсруулах, судалгаа шинжилгээ хийж, эмнэлгийн мэргэжилтэнг сургах, бусад эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зохицуулах чадавхийг бий болгож, хөгжүүлнэ.												
1.8.1	Оношилгоо эмчилгээний технологийн үнэлгээ хийх, шинэ технологийг нэвтрүүлэх, судалгаа шинжилгээ хийж, улсын хэмжээнд мэргэжлийн удирдлагаар хангаж буй өнөөгийн байдалд үнэлгээ хийнэ.	+	+				Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Үнэлгээний тайлан	ЭМСЯ-ны ХШУДАГ, ЭМХТ, Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 11.2	16 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 16 хүн/сар тус тус ажиллахаар тооцов.
1.8.2	Улсын хэмжээний мэргэжлийн лавлагаа дүгнэлт гаргаж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах журам, хариуцах байгууллагын жагсаалтыг мэргэжлийн салбар тус бүрээр батлан, хэрэгжүүлнэ.	+	+				Мэргэжлийн салбар бүрийн нэгдсэн удирдлага тодорхой болно.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 7.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 10 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.8.3	Улсын хэмжээнд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг мэргэжлийн салбар тус бүрээр боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+				Мэргэжлийн удирдлагаар хангах үйл ажиллагаа тодорхой болно.	Сайдын тушаал	Төв эмнэлэг тусгай мэргэжлийн төвүүд, Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 8.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 12 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 12 хүн/сар ажиллахаар тооцов.
1.8.4	Хүн амын өвчлөл, нас баралтын тэргүүлэх 5 шалтгаанаар 2040 он хүрэлх өвчлөлийн хэтийн төлөв, чиг хандлагыг судалж, тодорхойлно.		+	+			Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Судалгааны тайлан	ЭМХТ, ЭМСЯ ХШУДАГ	Судалгааны байгууллага, МУУСХ	Улсын төсөв 7.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 10 хүн/сар ажиллахаар тооцов.
1.8.5	Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх мэргэжилтний багийг орон нутагт богино хугацаагаар томилон ажиллуулах, мэс заслын явуулын багаар үйлчлэх ажлыг зохион байгуулна.		+	+	+		Орон нутагт үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	Сайдын тушаал	Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Аймгийн ЭМГ, НЭ	Аймгийн ЗДТГ	Улсын төсөв 60.0	Тухайн байгууллагын төлөвлөгөө, төсвийн хүрээнд тусган хэрэгжүүлнэ, орон нутагт ажиллах зардал, дадлагажуулах, явуулын багийн зардлыг тооцов.
Бодлогын чиглэл: 1.9 Хэвтүүлэн эмчилдэг зарим бичил мэс засал, ажилбар, дурангийн мэс засал, туяа болон гемодиализ эмчилгээ, биопси болон бусад оношилгоо, эмчилгээг өдрөөр хийхээр зохион байгуулж, эмнэлгийн шаардлагагүй хэвтэлтийг одоогийн түвшнээс 30-аас доошгүй хувиар												
1.9.1	Өдрийн эмчилгээний жагсаалт, оношилгоо эмчилгээний заавар, журам, анхан шатны маягыг боловсруулж, батлуулна.	+	+				Нотолгоонд суурилсан арга зүйн удирдамжаар хангагдана.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, ХШУДАГ,	Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 5.6	Хариуцсан байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 8 хүн/сар ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг.)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.9.2	Өдрөөр болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний орны дээд хязгаарыг хүн амын тоо, орны фонд ашиглалт, эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал, ачаалалтай уялдуулан шинэчлэн тогтооно.			+	+		Хүн амын хэрэгцээтэй уялдсан төлөвлөлт, зохицуулалт сайжирна.	Сайдын тушаал, Аймаг, нийслэлийн ЭМГ-ын даргын тушаал	ЭМСЯ-ны СБТГ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 15.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд 22 байгууллагад 0.7 сая төг-ийн цалинтайгаар 22 хүн/сар ажиллахаар тооцов.
1.9.3	Эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх өдрийн эмчилгээний багцыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	+	+				Өдрийн эмчилгээний нэр төрөл нэмэгдэж, шаардлагагүй хэвтэлт буурна.	ЭМД-ын Үндэсний зөвлөлийн тогтоол	ЭМСЯ-ны СБТГ, ЭМБХЗГ ЭТХ, СЭЗХ	ЭМД-ын байгууллага	Улсын төсөв 8.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 3 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 12 хүн/сар ажиллахаар тооцов.
Бодлогын чиглэл:												
1.10 Орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэн, одоо хийж чадахгүй байгаа өндөр нарийвчлал, технологи шаардсан эмнэлгийн тусламж, үйлчилгээг эх орондоо үзүүлж гадаадын ижил төстэй эмнэлгүүдтэй өрсөлдөх түвшинд хүргэнэ.												
1.10.1	Орон нутагт хэрэглэж байгаа оношилгоо, эмчилгээний технологийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, хоцрогдсон технологийн жагсаалтыг гаргаж, түүнийг өөрчлөх, шинэчлэн сайжруулах мэргэжил арга зүйн зөвлөмж, боловсруулна.	+	+				Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Мэргэжил арга зүйн зөвлөмжийн тоо	ЭМХТ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, Мэргэжлийн салбар зөвлөл	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 6.0 Улсын төсөв 14.0	Төсөл хөтөлбөрөөс мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хурал хэлэлцүүлгийн зардлыг санхүүжүүлж, нийт 10 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 20 хүн/сар тус тус ажиллахаар тооцов.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.10.2	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн тэргүүнд шинээр нэвтрүүлэх оношилгоо, эмчилгээний технологи, инновацийн хөтөлбөрийг мэргэжлийн салбар бүрээр боловсруулж, батлуулна.		+	+			Шинэ технологи нэвтрүүлэх нэгдсэн төлөвлөлт бий болно.	Засгийн газрын тогтоол	ЭМБХЗГ-ын ЭТХ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, Мэргэжлийн салбар зөвлөл	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 6.0 Улсын төсөв 2.8	Төсөл хөтөлбөрөөс мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, хурал, хэлэлцүүлгийн зардлыг санхүүжүүлж, хариуцсан байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 4 хүн/сар тус тус ажиллахаар тооцов.
1.10.3	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний шинээр нэвтрүүлэх дэвшилтэт технологи, инновацийг бүртгэх, түүнийг нэвтрүүлэхэд баримтлах журмыг боловсруулж, батлуулна.		+	+			Оношилгоо эмчилгээний шинэ технологийг бүртгэх эрх зүйн орчин бүрдэнэ.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ, ЭТХ, ТЗУГ, Мэргэжлийн салбар зөвлөл	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Улсын төсөв 2.8	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 4 хүн/сар ажиллахаар тооцов.
1.10.4	Оношилгоо, эмчилгээний заавар, зөвлөмж, стандарт, эмнэлзүйн удирдамж боловсруулах арга зүйн удирдамж батлан хэрэгжүүлнэ.		+	+			Нотолгоонд суурилсан арга зүйн удирдамжаар хангагдана.	Сайдын тушаал	ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 15.0 Улсын төсөв 1.4	Төсөл хөтөлбөрөөс Б хотод 40 хүнтэй сургалт 2 удаа зохион байгуулах зардлыг, улсын төсвөөс хариуцсан байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 2 хүн/сар ажиллахаар тооцов.
1.10.5	Өвөрхангай, Хөвсгөл, Ховд, Дархан-Уул 4 аймагт цусны загвар банк байгуулж, цус цуглуулах суурин цэгүүдийг нэмж байгуулна.			+	+	+	Цус цусан бүтээгдэхүүний хангамж сайжирна.	Улсын комисс хүлээн авсан дүгнэлт	ЭМСЯ-ны ЭМБХЗГ, ЦССҮТ, ЭМСХХ-5 төсөл	СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ	Улсын төсвөөс 1,425.0 төслөөс 19,870.0	УИХ 2013 оны 5 сарын 10-ний өдөр соёрхон баталсан ЭМСХХ-5 төслийн хэлэлцээрт тусгасан төсвийг үндэслэн тооцсон.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
1.10.6	Настны эрүүл мэндийн үзлэг, сувилахуйн удирдамж, "Олон мэргэжлийн тусламж, үйлчилгээний удирдамж"-ийг батлан улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.		+	+			Нотолгоонд суурилсан арга зүйн удирдамжаар хангагдана.	Батлагдсан заавар, удирдамж, түүний сургалтууд	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, Геронтологи үндэсний төв	Аймаг нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 8.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 12 хүн/сар ажиллахаар тооцов.
1.10.7	Бөөр орлуулах эмчилгээ, бөөрний эдийн шинжилгээ, дархлал судлалын шинжилгээний чадавхийг нэмэгдүүлнэ.		+	+			Эмчилгээний чанар сайжирна.	Холбогдох тушаал шийдвэр, тайлан	ЭМСЯ-ны ЭМБХЗГ ЭТХ, СБТГ СЭЗХ, УНТЭ,	СЯ,	Улсын төсөв 350.0	7 аймагт диализын усны систем авах хөрөнгө оруулалтын зардлыг тооцсон.
1.10.8	Амьсгалын тогтолцооны өвчин, харшлын гаралтай багтрааны оношлогоо, эмчилгээний стандартыг шинэчлэн боловсруулж, батлуулна.	+	+				Нотолгоонд суурилсан арга зүйн удирдамжаар хангагдана.	Батлагдсан стандарт	ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	СХҮТ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 3.0 Улсын төсөв 1.4	Төсөл хөтөлбөрөөс хурал, хэлэлцүүлгийн зардлыг санхүүжүүлж, хариуцсан төсвийн байгууллагад 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 2 хүн/сар тус тус ажиллахаар тооцов.
1.10.9	Гепатитын В, С вирусээс улбаалсан элэгний эмгэгийн чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үр дүнтэй эмчлэх арга зам, технологийг нэвтрүүлнэ.	+	+	+	+	+	Шинэ технологи нэвтэрсэн байна.	Тушаал шийдвэр, үйл ажиллагааны тайлан	ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын ЭТХ, ХӨСҮТ, Мэргэжлийн салбар зөвлөл	СЯ, ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 150,000.0 Улсын төсөв 150,000.0	В, С вирусын эсрэг шинээр гарч буй эмийг эмнэлэгт хэрэглэх 150,000 хүний эмчилгээний эмийн нийт 300 тэрбум төгрөгний 5 жилийн зардлыг тооцов.
1.10.10	Монголд шинээр нэвтрүүлж буй оношилгоо, эмчилгээний чиглэлээр өндөр хөгжилтэй орноос мэргэжилтэнг урьж ажиллуулах, харилцан туршлага солилцох эмнэлэг хоорондын шууд хамтын ажиллагааг өргөжүүлнэ.		+	+	+	+	Шинэ технологийг нэвтрүүлэх мэдлэг, ур чадвар нэмэгдэнэ.	Үйл ажиллагааны тайлан	ЭМСЯ-ны ЭМБХЗГ-ын ЭТХ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 120.0	Төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр тооцсон.

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
Бодлогын чиглэл:												
1.11 Телемедицины оношилгоо, эмчилгээний үндэсний сүлжээг бэхжүүлж, иргэдийг орон нутгаасаа чанартай оношилгоо, эмчилгээ авах боломжийг нэмэгдүүлнэ.												
1.11.1	Телемедицины үндэсний сүлжээнд бүх сумдыг үе шаттайгаар бүрэн холбох төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+	+		Шийдвэр гаргах үндэслэл, нотолгоо бүрдэнэ.	Судалгааны тайлан	ЭМСЯ СБТГ СЭЗХ, ЭМХТ,	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУБ	Төсөл хөтөлбөр 3.0 Улсын төсөв 1.4	Төсөл хөтөлбөрөөс хурал, хэлэлцүүлгийн зардлыг санхүүжүүлж, ЭМХТ-ийн ажилтнууд дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 2 хүн/сар тус тус ажиллахаар тооцов.	
1.11.2	Телемедицины сүлжээгээр үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, мэргэжил арга зүйн зөвлөгөөний давтамж, хариуцах байгууллагын хуваарийг батлан, хэрэгжүүлнэ.		+			Телемедицины тусламж, үйлчилгээний эрх зүйн тодорхой болно.	Сайдын тушаал	ЭМХТ, ЭМБХЗГ ЭТХ, Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд	Аймаг, нийслэлийн ЗДТГ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 8.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 12 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 12 хүн/сар ажиллахаар тооцов.	
1.11.3	Өвчний цахим түүхийн өгөгдлийн өндөр нууцлал бүхий программ хангамжийг боловсруулан, нэвтрүүлнэ.		+	+		Телемедицины тусламжийг чанартай үзүүлэх нөхцөл бүрдэнэ.	Программ хангамжийг хүлээн авсан шийдвэр	ЭМХТ, ЭМСЯ-ны ХШУДАГ, ЭМБХЗГ ЭТХ	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 30.0	Өгөгдлийн өндөр нууцлал бүхий өвчний цахим түүхийн программ хангамж боловсруулах, хөгжүүлэх зардлыг тооцов.	
1.11.4	Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх, хянах, хүлээн авах мэдээллийн программ хангамжийг боловсруулан хэрэгжүүлнэ.		+	+	+	Өвчтөн шилжүүлэх цахим тогтолцоо бүрдэнэ.	Программ хангамжийг хүлээн авсан шийдвэр	ЭМХТ, ЭМСЯ-ны ХШУДАГ, ЭМБХЗГ ЭТХ, Мэргэжлийн салбар зөвлөл	ОУБ, Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Төсөл хөтөлбөр 20.0	Программ хангамж боловсруулах, хөгжүүлэх зардлыг тооцов.	
1.11.5	Телемедицины үйлчилгээг өргөжүүлэх, цахим тогтолцоог хэрэгжүүлэхэд шаардагдах эдийн засгийн тооцоо судалгааг хийж, холбогдох зардлыг төсөвт тусгах арга хэмжээг зохион байгуулна.		+	+	+	Телемедицины үйлчилгээг өргөжүүлэх санхүүгийн орчин нөхцөл бүрдэнэ.	Судалгааны тайлан батлагдсан төсөв	ЭМХТ, ЭМСЯ-ны СБТГ, СЭЗХ, Аймаг, нийслэлийн ЭМГ	СЯ, Аймаг нийслэлийн ЗДТГ	Улсын төсөв 16.8	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 24 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 24 хүн/сар ажиллахаар тооцов.	

No	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа					Гарах үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хариуцах газар, хэлтэс, байгууллага	Хамтрах байгууллага	Шаардагдах санхүүжилт, эх үүсвэр (сая. төг)	Тайлбар
		2015	2016	2017	2018	2019						
Стратеги 2. Нотолгоонд суурилсан оношилгоо эмчилгээний үр дүнтэй арга, технологийг нэвтрүүлж, чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн эмнэлзүйн эрсдлийн удирдлага, магадлан итгэмжлэлийн тогтолцоог бэхжүүлнэ.								Хүлээгдэж буй үр дүн 1 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирсан байна.				
Бодлогын чиглэл: 2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангаж, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын үндэсний зорилтуудыг боловсруулж, хэрэгжүүлнэ.												
2.1.1.	Тусламж, үйлчилгээний чанарын ойлголт, нэр томъёо, чанарын ахиц дэвшлийг үнэлэх шалгуур тодорхой болгож, "Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлнэ.	+	+	+	+		Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирна.	Засгийн газрын тогтоол, хэрэгжилтийн тайлан, үнэлгээ	ЭМСЯ-ны СБТГ, СЭЗХ, ЭМБХЗГ, ТЗУГ, ЭМХТ	МХЕГ, ЭМД-ын байгууллага, СХҮТ, Мэргэжлийн нийгэмлэг холбоо	Улсын төсөв 14.0	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 2 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар 20 хүн/сар ажиллахаар тооцов.
2.1.2	Ажлын байрны эмх цэгцийг сайжруулах Японы "5С" аргыг эрүүл мэндийн байгууллага бүрт нэвтрүүлнэ.	+	+				Эмнэлгийн тусламж, үйлчилгээний эмх цэгц сайжирна.	Ажлын тайлан	Аймаг, нийслэлийн ЭМГ, Эрүүл мэндийн байгууллага	Мэргэжлийн нийгэмлэг, холбоо	Улсын төсөв 15.4	Тухайн байгууллагын төсвийн хүрээнд нийт 22 байгууллагад дунджаар 0.7 сая төг-ийн цалинтайгаар нийт 22 хүн/сар ажиллахаар тооцов.
